

**«ТАЙВАНЫ ТУХАЙ МАРГААН»  
НОМЫН ТАЛААР**

(Andrzej Halimarski «Spor o Taiwan»,  
Warszawa, 1986. h, 305)

БНПАУ-ын хятад судлаач Анджей Халимарскийн бичсэн «Тайваны тухай маргаан» номыг Польшийн «Ном, мэдлэг» Хэвлэлийн газар 1986 онд хэвлэн гаргажээ. Тайваны түүх, улс төр, нийгэм-эдийн засаг, гадаад харилцааны тухай бичсэн энэ ном өмнөх үг, 8 бүлгээс бүрдэнэ.

«Тайваны тухай маргаан» номын нэгдүгээр бүлэгт хятадын түүхийн анхны бичлэг «Шан Шу» (МЭӨ III зуун)-аас эхлэн бичигдсэн түүхэн сурвалж бичгүүдэд өгүүлэгдсэн одоогийн Тайваны газар зүй, хүн амын суурьшил хийгээд арал дээр болж өнгөрсөн үйл явдлуудыг цэгц дараалалтай бичжээ. Түүхийн эх сурвалжаас үзэхэд одоогийн Тайваны уугуул хүн амын үүсэл гарлын асуудал маргаантай хэвээр байна. Нэлээд гүйцэд баримттай тулгар бичиг гэгддэг «Суй-Шу»-д (Суй улсын түүх) өгүүлснээр Хятадын Суй улсын (МЭ 589—618 он) хаан Ян Дийн тушаалаар адмирал Жугуан «Гайхалтай газар» руу («Хөвөгч газар» буюу Тайван) далайн аялал хийсэн тухай илтгэлдээ арлын хүн ам тэдгээрт нөхөрсгөөр хандаж байсан авч хэл ойлголцохгүй байв гэж дурдсан нь сонирхолтой баримт болж үлджээ.

Тайван арлын түүхэнд монголын хаанчлалын түүхтэй холбогдох зүйлүүд мөн бий аж. Монголын ноёрхолд орсон XIII зууны үед Хятадын далайн эрэг дагуу орших Жэзын, Фузяны хүн ам монголын түрэмгийллээс үй олноороо нүүн зугтсан тухай тэмдэглэл байдаг бөгөөд тэдгээр нь эх газраас Тайванд очиж суурьшсан анхны хүмүүс юм гэсэн таамаглалыг зохиогч дэвшүүлсэн байна. Монголын эзэн хаад Хятадын өмнөх хаадыг бодвол Дорнод Хятадын тэнгэс, Өмнөд Хятадын тэнгэсийн арлуудыг түрэмгийлэх бодлогоо идэвхжүүлэн Тайваныг эзэгнэх зорилгоор арал дээр цэргийн хүч байрлуулах шийдвэр гаргаж 1292 онд адмирал Янцин тэргүүтэй далайн аян илгээсэн нь амжилт олсонгүй аж.

1294 онд Хубилай хаан Тайван арлыг Хятадын Фузян мужийн Зинцян тойрогт багтааснаар тус арал хятадын захиргаанд албан ёсоор оржээ.

«Тайваны тухай маргаан 1945—1969 онд» гэсэн бүлэгт Японы засгийн газар Потсдамын тунхаглалын шаардлагыг хүлээн авч 1945 оны 10-р сарын 25-нд Тайван эх газартаа эргэн орсонд тооцогдсоноос хойшхи үед арал дээр гарсан улс төр, дотоод бодлогын өөрчлөлт, тус аралтай холбогдолтой олон улсын харилцааны ээдрээтэй асуудлыг өгүүлнэ.

«НҮБ-ын чуулган, хуралдаануудад Тайваны асуудал» III бүлэгт БНХАУ НҮБ-ын гишүүнээр зүй ёсоор элссэнээс хойш ч хөрөнгөтөн орнууд Тайваны асуудлыг олон улсын хэмжээний асуудал болгон дэвэргэж «Тайваны хуулийн статус шийдвэрлэгдээгүй», «Хоёр Хятад», «Нэг Хятад, нэг Тайван», «Нэг Хятад, хоёр удирдлага», «Тусгаар тогтносон Тайван» гэх зэрэг олон янзын үзэл бодол дэвшүүлэн БНХАУ-ын дотоод хэрэгт бүдүүлгээр оролцож ирснийг зохиогч шүүмжлэн тусгажээ.

Энх тайван аюулгүй байдал, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэсэн олон улсын хамгийн нэр хүндтэй байгууллага-НҮБ-д БНХАУ гишүүнээр элсэн орсны дараа дэлхийн олон орон БНХАУ тай дипломат харилцаа тогтоон хөгжүүлэн ирсэн тухай бичсэн.

Дэлхийн олон орнууд БНХАУ-тай дипломат харилцаа тогтоон хөгжүүлэн ирсэн тухай бичсэн IV бүлэгт БНХАУ байгуулагдмагц Хятадын засгийн газрыг хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоосон ЗХУ, социалист бусад орнууд «Хоёр Хятад» гэгч үзэл бодлыг эрс шүүмжилж Тайван Хятадын салшгүй хэсэг гэдэг байр сууриа ямагт илэрхийлж ирснийг өгүүлжээ.

Нөгөө талаар хөрөнгөтөн орнууд БНХАУ-тай дипломат харилцаа тогтоохдоо Тайваны асуудлаар олон янзын томъёолол гаргасан байна. Тухайлбал Франц, Канад, Их Британи, Голланд, Япон, ХБНГУ зэрэг орны дэвшүүлсэн томъёоллуудыг А. Халимарский сайтар задлан шинжилжээ. Жишээлэхэд, БНХАУ, ХБНГУ 1972 оны 10-р сарын 11-нд дипломат харилцаа тогтоохдоо ХБНГУ Хятадын талаас дэвшүүлсэн Тайван нь БНХАУ-ын нутаг дэвсгэрийн нэг хэсэг мөн гэсэн мэдэгдлийг анхааралдаа авч БНХАУ-ын засгийн газрыг Хятадын цорын ганц хууль ёсны засгийн газар гэдгийг хүлээн зөвшөөрөв. ХБНГУ Тайвантай албан бусаар эдийн засаг, соёл, харилцан айлчлах зэрэг харилцаа хөгжүүлэх эрхтэй гэдгийг БНХАУ-ын тал хүлээн зөвшөөрөв гэж хоёр орны засгийн газрын хамтарсан мэдэгдэл дурджээ.

«Америк-хятадын харилцаа хэвийн болсон үе, Тайваны тухай маргаан шинэ шатанд гарсан нь» гэсэн V бүлэгт АНУ-ын засгийн газар, БНХАУ-ыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөхөд олон саад тотгор тавьж ирсэн бодлого нь балран унаж БНХАУ-ыг арга буюу хүлээн зөвшөөрөхөд Тайваны асуудлын талаар хоёр талын эзэлсэн байр суурийн тухай өгүүлжээ.

БНХАУ, АНУ-ын хоорондын харилцаа хэвийн болсон явдал америк-тайваны харилцаа холбоо, арал дээрх дэглэмийн байр суурийг сулруулаагүй бөгөөд Тайван Вашингтоны улс төр, цэрэг стратегийн бодлогод чухал байр суурь эзэлсэн хэвээр байгаа бөгөөд АНУ хэрэг дээр «Нэг Хятад, нэг Тайван» гэгч үзэл бодлыг баримталж байна гэж А. Халимарский дүгнэжээ.

«Тайван 1945—1984 онуудад» хэмээх VI бүлэгт тус арлын нийгэм эдийн засгийн байдал, улс төрийн систем, Тайван-барууны орнуудын харилцаа, сүүлийн жилүүдэд арлын эдийн засаг хэрхэн хөгжиж ирснийг тоо, баримтад тулгуурлан нэлээд дэлгэрэнгүй үзүүлжээ.

«БНХАУ ба Тайван 70, 80-аад оны эхэнд» VII бүлэгт сүүлийн жилүүдийн харилцаанд гарсан үйл явдлыг өгүүлжээ. Тайваныг эх нутагтаа эргүүлж багтаах нь БНХАУ-ын батлан хамгаалахыг бэхжүүлэн гадаад бодлогын олон асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдол үзүүлэх ёстой билээ. БНХАУ тус арлыг эх газарт нэгтгэх бодлого явуулахдаа «имянь лай» (ойртуулах), «имянь да» (тэмцэх) тактик хэрэглэж ирснийг зохиогч тоймлон харуулжээ. Нэг талаас Тайваныг бүхий л аргаар эх газарт нэгтгэхэд чиглэгдсэн БНХАУ-ын бодлого, нөгөө та-

лаас «Ямар ч ярилцлага явуулахгүй», «ямар ч харилцаа тогтоохгүй», «Ямар ч буулт хийхгүй» гэсэн Тайваны удирдагчдын бодлогод сүүлийн жилүүдэд өөрчлөлт гарч эхэлж байна гэсэн дүгнэлтийг зохиогч хийжээ. Гэхдээ БНХАУ-ын эдийн засаг өндөр түвшинд хүрч, Алс Дорнодод Бээжингийн эзлэх байр суурь, түүний гүйцэтгэх үүрэг роль чухал ач холбогдолтой болсон тэр цагт Тайван эх газартаа эргэн багтах асуудал шийдвэрлэгдэх юм хэмээн А. Халимарский дүгнэн бичжээ.

**Н. Баярбаатар**